

1. Төрийн хяналт, иргэн таны төлөө сарын аяны хүрээнд Саян телевизээр МХГ, ЭМГ хамтарсан цуврал ярилцлага болж гэдэсний халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, гарын эрүүл ахуйг сахих сэдвээр ярилцлага өгсөн.
2. Төрийн хяналт-иргэн таны төлөө сэдэвт сарын аяны хүрээнд зохион байгуулагдсан Хууль сурталчлах өдөрлөгт оролцсон. Тус өдөрлөгт гэдэсний халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, гарын эрүүл ахуйн талаар мэдээлэл сургалт сурталчилгаа хийж 100 ширхэг гарын авлага тараасан.
3. 2018 оны 9 дүгээр сарын 5-ны өдөр Монгол улс дахь НҮБ-ын Хүүхдийн сангийн төлөөлөгч нарын уулзалт хэлэлцүүлэт оролцсон тус хэлэлцүүлэгт үерт өртсөн сургууль, цэцэрлэг болон ард иргэдэд ариутгал халдваргүйтгэлийн чиглэлээр санхүүгийн дэмжлэг үзүүлэхээр боллоо.
4. Үерт өртсөн айл, өрх болон байгууллагуудын ариутгал халдваргүйтгэлийн үйл ажиллагаа явагдаж байна. Үүнд 2018 оны 09 дүгээр сарын 03-ний өдрөөс 9 дүгээр сарын 13-ны өдөр хүртэл Өлгий сумын 13, 3 дугаар багийн үерт автагдсан нийт 13400 м2 газарт ариутгал халдваргүйтгэл хийгдсэн.
5. “Тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлье” 3 сарын аяны хүрээнд 2018 оны 09 дүгээр сарын 06-ны өдөр Аймгийн Засаг даргын тамгын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Мэргэжлийн хяналтын газар, Онцгой байдлын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Цагдаагийн газар, Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, Өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй хамтран тус аяны хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажлын талаар мэдээлэл хийж, тэмцээн зохион байгуулж Нэгдсэн эмнэлгийн яаралтай тусламжийн тасаг эхний байрыг эзэлсэн. Мөн ард иргэдэд тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар зөвөлгөө өгч 300 ширхэг гарын авлага тараасан.

Зарим статистик үзүүлэлтүүд

Нийт төрөлт - 28

Амьд төрөлт - 28

Амьгүй төрөлт- 0

Дутуу төрөлт - 1

Нялхсын эндэгдэл- 2

1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл- 1

Эхийн ноцтой хүндрэл- 0

Төрөлхийн гажиг- 1

Гэрийн төрөлт- 0

Аймгийн хэмжээнд амбулаторид суурилсан томуугийн харуулдан тандалтын 18 нэгжүүдэд 36 дугаар долоо хоногт нийт 3009 хүн үйлчлүүлсний 47(1,5%) нь ТТӨ-тэй тохиолдол бүртгэгдсэн байна. Өмнөх 7 хоногтой харьцуулахад 1,7%-иар буурсан үзүүлэлтэй байна.

Амьсгалын замын цочмог хүнд халдварын шалтгаантай эмнэлэгт хэвтэгсэд нийт хэвтэгсэд (122)-ийн дотор буюу 4,9 %-ийг эзэлж, өмнөх долоо хоногтой харьцуулахад 4,3%-иар буурсан үзүүлэлтэй байна. Уушгины үрэвслийн шалтгаантай нас баралт бүртгэгдээгүй байна.

Аймгийн хэмжээнд түргэн тусламжийн 239 дуудлагын 18 (7,5%)-ийг ТТӨ-ий шалтгаантай дуудлага эзэлж байна. Өмнөх долоо хоногтой харьцуулахад 2,4%-иар буурсан үзүүлэлтэй байна.

Аймгийн хэмжээнд 2018 оны 36 дугаар 7 хоногт аймгийн Нэгдсэн эмнэлэг, сумын тандалтын нэгжүүд Томуу, томуу төст өвчний тохиолдол 18 удаа ирүүлэхээс 18(100%) удаа ирүүлсэн байна.